



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

“Тэргүүн зоос” ХЗХ-нд санхүүгийн түрээсийн болон т
төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх
үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 5.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 82 дугаар тогтоолын 1.1, 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тэргүүн зоос” ХЗХ-нд санхүүгийн түрээсийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зөвшөөрлийн талаарх тэмдэглэгээг 2014 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн дотор хийлгэхийг “Тэргүүн зоос” ХЗХ /гүйцэтгэх захирал С.Хэнмэдэх/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН